



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/196

Эрдэнэт

Г Улсын Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", 29.1.5 "в", 29.1.6 "л", 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 45, 78, 91 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын хэмжээнд 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд аймгийн хэмжээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй. Үүнд:

1.1.Баян-Өндөр, Жаргалант сумдын хэмжээнд диско, паб, караоке, пиво баарны үйл ажиллагааг түр зогсоосон хугацааг сунгаж, архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 06.00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 00.00 цаг хүртэл хориглосугай.

1.2.Боловсрол, соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг цахимд шилжүүлсэн хугацааг 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл сунгасугай.

1.3.Аймгийн хэмжээнд амралтын газар болон зочид буудлуудын үндсэн үйл ажиллагааг түр зогсоож тусгаарлах байрны зориулалтаар ашиглахаар шийдвэрлэсэн хугацааг 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл сунгасугай.

1.4.Байгууллага салбарынхаа хэмжээнд дархлаажуулалт, ариутгал, халдваргүйтгэлийг зохион байгуулж, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа (спорт зааланд тоглох, сургалт, семинар, цугларалт, уншлага, хэлэлцүүлэг, PC тоглоом, фитнес, спиннинг, нийтийн бүжиг)-г 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулахгүй байхыг иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад даалгасугай.

1.5.Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүд, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Эмнэлэг сувиллын цогцолбор болон бусад эмнэлгүүд, дархлаажуулалтын цэгүүдийн бэлэн байдлыг хангаж ажиллуулах, бусад байгууллагууд, хуулийн этгээд байгууллага дээрээ зохицуулалт хийж, зайлшгүй шаардлагатай албан тушаалтнуудаас бусад албан хаагчдыг дээрх хугацаанд ажиллуулахгүйгээр цалин хөлсийг тооцож олгохыг зөвшөөрсүгэй.

1.6 Улсын Онцгой комиссын 2021 оны 02 дугаар тогтоол болон аймгийн Засаг даргын 2021 оны А/151, А/167, А/179, А/186 дугаар захирамжуудаар өгөгдсөн үүргүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.

2.Тогтоосон хугацаанд аймгийн хэмжээнд хот хооронд болон орон нутгийн зорчигч тээврийн хэрэгслийн үйл ажиллагааг зогсоож, нийтийн тээврийн үйл ажиллагааг өглөө 07.00 цагаас 09.00 цаг, орой 17.00 цагаас 20.00 цаг хүртэл тогтоосон чиглэлийн дагуу явуулах зохицуулалт хийж, хяналтын цэгүүдийг гарган ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (С.Даваадорж), Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Авто тээврийн төв (Г.Ядмаа), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр) нарт үүрэг болгосугай.

3.Коронавируст халдвар цаашид хүн амын дунд тархах эрсдэлтэй байгаа тул иргэн бүр онцгой анхаарч аль болох гэрээсээ гарахгүй байх, олон нийтийн газраар явахгүй байх, гэр-ажил-гэр гэсэн маршрутыг мөрдөн, амны хаалтыг байнга хэрэглэн, гараа тогтмол ариутган, халдвар хамгааллын дэглэмийг сахиж, хариуцлагатай байхыг аймгийн нийт иргэддээ уриалсугай.

4.Тогтоосон хугацаанд хүнсний нөөц хангамжийн асуудлыг хэвийн хэмжээнд байлгаж, хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өсгөхгүй байхад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Бат-Өлзий, Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Жигдэнгомбо, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын Улсын байцаагч Н. Баясгалан нарт даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагааны талаар иргэдэд үнэн зөв мэдээллийг тогтмол цагт хүргэж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Соёлчхүү), Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр)-нд тус тус үүрэг болгосугай.

6.Энэхүү захирамжийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Авто тээврийн төв (Г.Ядмаа), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр) нарт үүрэг болгосугай.

7.Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гудамж талбайд хүүхэд, залуучууд сэлгүүцэх, бөөгнөрөл үүсгэх асуудалд онцгой анхаарч тодорхой арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Боловсрол, соёл, урлагийн газар (О.Ариунгэрэлт), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (А.Наранболд), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр) нарт даалгасугай.

8.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч А.Түвшинжаргал, аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Ганбаатар нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  С.БАТЖАРГАЛ